



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

2022

Ж И Л И Й Н Т А Й Л А Н



www.bogdbank.com



АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

- Компанийн танилцуулга
- ТУЗ-ийн даргын мэндчилгээ
- ТУЗ-ийн гишүүд
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Удирдлагын баг
- Компанийн бүтэц зохион байгуулалт
- Дотоод аудит
- Хүний нөөцийн бодлого
- Эрсдэлийн удирдлага

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

- Бизнесийн үйл ажиллагаа
- Салбарын удирдлага
- Мэдээлэл технологи
- Хөрөнгө зохицуулалт
- Зээлийн нэгдсэн удирдлага
- Санхүүгийн үзүүлэлт

БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Богд банк нь 2014 оноос хойш энэхүү баялаг түүхтэй банкны салбарын хамгийн отгон нь болж мэндэлсэн хэдий ч богино хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж Монголын зах зээлд өөрсдийн гэсэн байр сууриа эзлэн, орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, харилцагч олон түмэндээ танигдсан шинэ зууны банк болохоор зорин ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Дэлхийн шилдэг стандарт, туршлага, шинэ үеийн хандлага боломж, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг төдийгүй ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч банк байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчдынхаа сэтгэл ханамжийг тэнцвэртэй, тогтвортой хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн үзүүлэлтээрээ олон улсын жишигт хүрсэн, харилцааг эрхэмлэсэн, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч, технологид суурилсан банк байна.



ҮНЭТ ЗҮЙЛС

Банкны ажилтан бүр эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ/TRUST гэсэн монгол, англи үгээр товчлогдон илэрхийлэгдэх эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг цаг ямагт мөрдөж ажиллана.

И

Итгэлтэй банк, хамтрагч, зөвлөгч банк байж итгэлээр тэтгэх

Т

Тэгш, Шударга хандах

Г

Гарамгай, мэргэшсэн, чадварлаг ажилтнууд

Э

Эвсэг, бүтээлч баг хамт олон байх

Л

Шинэлэг, давшингуй байж тасралтгүй хөгжих

Т

Trustworthy bank, financial partner

Р

Reliable, fair equal treatment all

U

Unquestionably skillful dedicated professional


С

Sensible respectful harmonious team

Т

Truly innovative, nonstop progressing bank

БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Богд банк нь 2021 онд анхны олон нийтэд нээлттэй арилжааны банк болох шанг амжилттай татаж байсан бол 2022 оны онцлох ажлын тайлангаараа дамжуулан эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, түнш байгууллагууд болон харилцагч нартаа мэндчилж байгаадаа баяртай байна.

Өнгөрсөн 2022 онд дэлхийн дахинд цар тахлын хатуу арга хэмжээг суларч, эдийн засгийн эргэлт сайжирсан хэдий ч БНХАУ-ын "Тэг ковид" бодлого, Европын эрчим хүчний түүхийн эдийн хямрал Орос Украины зэвсэгт мөргөлдөөн зэрэг нь дэлхийн зах зээл дэх нийлүүлэлтийг бууруулж, цаашлаад Монгол улсын эдийн засгийн хувьд ч том цохилт болсон жил байлаа.

Харин Богд банкны хувьд банкны салбарт тогтсон уламжлалт зах зээлийг шинэ өнгө төрхөөр цахим шийдлийг үйл ажиллагаандаа ухаалгаар нэвтрүүлж байгаа нь санхүүгийн зах зээл дээр тогтвортой өсөлттэй тэргүүлэгч байх давуу тал гэж харж байна.

Бид олон улсын хамтын ажиллагааг улам өргөжүүлэн Enabling Capital хөрөнгө оруулалтын сан, олон улсын хөгжлийн санхүүжилтын корпорацаас (DFC) тус тус санхүүжилт амжилттай татсан билээ. Мөн АНУ-Монгол улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх Америкийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр ажилладаг АмЧам Монголын гишүүн байгууллага болж хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэллээ.

Богд банк нь ирэх жилүүдэд стратегийн түвшинд үйл ажиллагаа улам сайжруулан нээлттэй ил тод байх зарчмаа ямагт баримтлан салбартаа тэргүүлэгч, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг нэвтрүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Банкныхаа өсөлт хөгжилт бүх цаг үед хамт байж, амжилт бүтээлийн оргил рүү хамт тэмүүлж буй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хувьцаа эзэмшигчид, нийт ажилтнууд болон тэдний гэр бүлд гүнээ талархал илэрхийлье.

Л.БОЛДХУЯГ
ТУЗ-ИЙН ДАРГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ




Л.БОЛДХУЯГ
ТУЗ-ийн дарга




Г.САРУУЛ
ТУЗ-ийн гишүүн



Э.БЯМБАЖАВ
ТУЗ-ийн хараат бус гишүүн




Ж.НАРАНТУЯА
ТУЗ-ийн хараат бус гишүүн




Рожер Томас Мойес
ТУЗ-ийн хараат бус гишүүн




Д.МОЛОМЖАМЦ
ТУЗ-ийн гишүүн



ЖАН ТОРСТЭН Дазер
ТУЗ-ийн гишүүн




Эллиот Рован Аукланд
ТУЗ-ийн гишүүн



Б.ОЙГОНЖАРГАЛ
ТУЗ-ийн гишүүн

ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ТӨРМАНДАХ
Ерөнхий аудитор



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Г.САРУУЛ

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал

Богд банк нь хамтран ажилладаг түнш байгууллага, харилцагч болон хувьцаа эзэмшигч нартаа 2022 оны онцлох ажлын тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна.

Манай банк дотооддоо харилцагч үйлчлүүлэгчдэдээ хэрэгцээ шаардлагад тохирсон салбартаа анхдагч бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг нэвтрүүлж чадсан онцгой жил байлаа. Мөн олон улсын Enabling Capital хөрөнгө оруулалтын сан, олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацаас (DFC) тус тус санхүүжилтийг татаж, хамтын ажиллагааг тэлж ажиллалаа.

Бидний ажлын хамгийн чухал үр дүн үзүүлэлт болох ашгийг 76.9% өсөж, нийт зээл 41% өсөж 208.6 тэрбумд хүрсэн. Хүүгийн орлого 70.8% өсөж 45.6 тэрбум хүрсэн. Ашигт ажиллагаа 79.9% өсөж, 19.1 тэрбум төгрөгт хүрчээ. Харилцах, хадгаламжийн хэмжээ 58.5% өсөж, 217.2 тэрбум төгрөгт хүрсэн амжилттай жил байлаа. Бидний хөдөлмөрийг үнэлж, өндөр өсөлт энэ амжилтад итгэж, итгэл үзүүлэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчдэдээ хоёрдугаар улирлын цэвэр ашгаас ногдол ашгийг тараах шийдвэрийг гаргасан.

Бусдаас ялгарах гол онцлог бол харилцагчдын хүсэл, шаардлагыг мэдэрч, бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх байдаг ба бид анх удаа харилцагч дансны дугаараа дураараа сонгох, Prime, Prime reserve кредит картын бүтээгдэхүүн, анхны Мета банк буюу виртуал орчинд банкны бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг авахаас гадна "gamification" буюу тоглоом тоглон B-point урамшууллын лоялти оноогоо цуглуулан өөрийн данс руугаа шилжүүлэх зэрэг үйлчилгээг нэвтрүүлсэн. Мөн хугацаатай хадгаламжийн хоногийг хугацаагаар сонгох, байгууллагын харилцагч нартаа зориулж corporate gateway үйлчилгээг харилцагч нартаа шинээр нэвтрүүлж ажиллав.

Бид 2022 онд Монголбанк, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын "Шпаркасс" банкны Монгол дахь сан, нийт арилжааны банкууд хамтран "Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая" уриан дор хийгдсэн Дэлхийн хуримтлалын аянд дэд байранд шалгарч, өмнөх жилийн амжилтаа ахиулж чадсан жил байлаа.

Богд банк нь 2023 ондоо ч олон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхээр зорьж, бэлтгэл ажлаа эхлүүлсний нэг нь дотоодын ₮ картаар хилийн чанадад монгол дахь данс руу чөлөөтэй орлого, зарлага хийн төлбөр хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлэхээр туршилтын гүйлгээг хийн ажиллаж байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд олон томоохон ажлыг хийхээр төлөвлөн хэрэгцээ шаардлага нь үүссэн байгууллагуудад өөрийн дэмжлэгийг үзүүлэхээр ажиллаж эхлээд байна.

Салбартаа үргэлж шинийг санаачилж, байгууллагынхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэдэг нийт ажилтнууд, тэдний гэр бүл болон богд банкны хамт олны хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийг үнэлж, өндөр өсөлт, хурдацтай ахиц дэвшилд итгэл үзүүлэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчдэдээ гүнээ талархал илэрхийлье.


ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г.САРУУЛ
Гүйцэтгэх захирал



С.ОРГОДОЛ
Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч



Б.БИЛЭГТ
Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал



М.АЛТАНБАГАНА
Бизнес банк хариуцсан дэд захирал



М.АЛТАНЗҮРХ
Мэдээлэл технологи хариуцсан дэд захирал




Ч.БАНЧИН
Бизнес хөгжил хариуцсан дэд захирал



С.ОТГОНЖАРГАЛ
Зээл хариуцсан дэд захирал



М.БАТ-ӨЛЗИЙ
Санхүү хариуцсан дэд захирал



Э.ГАН-ЭРДЭНЭ
Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал

ДОТООД АУДИТ


Банкны дотоод аудитын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд байх Дотоод аудитын газар хариуцан ажилладаг. Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, бодитойгоор үзүүлж байна. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх удирдлага болон бусад нэгж, үйл ажиллагаанаас хараат бус байдаг ба ажлаа ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай сайжруулах ажлуудыг цаг тухайд нь хийлгэдэг.

Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан арга, аргачлалын үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд ТУЗ-өөс баталсан аудитын төлөвлөгөөний дагуу баталгаажуулалт хийж, банкны дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулах, гарсан алдаа, дутагдлыг засах, үйл ажиллагааг сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлага болон газар, нэгжид мэргэжлийн зөвлөмж өгч ажиллаж байна.

Тус газар нь Дотоод аудиторчуудын олон улсын институт (IIA Global)-ээс гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework)-г үйл ажиллагаандаа жишиг болгон ажиллаж байна. Мөн мэдээллийн технологийн аудитыг COBIT-2019 стандартад нийцүүлэн хийж, дотоод аудитын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна банкныхаа эрсдэлийг бууруулах, хамтын ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллаа.

Тайлант 2022 он нь Дотоод аудитын газрын хувьд дараах онцлог бүхий жил байлаа. Үүнд:

1. Ажилтнуудаа сургах, хөгжүүлэх, боловсруулах чиглэлд идэвхитэй ажилласан, түлхэц үзүүлсэн, улмаар ажилтнуудаас маань Олон улсын болон Монгол улсын мэргэшсэн цол зэргийг авсан жил байв,
2. Банкны дотоод хяналтын үйл ажиллагаанд зөвлөх чиглэлд ажиллаж "Богд банкны залилангийн эсрэг баримтлах бодлого"-ыг холбогдох газруудтай хамтран боловсруулж, батлуулав.
3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд аудитын тайлангуудыг танилцуулж, Дотоод аудитын газраас гаргасан санал, дүгнэлт, үнэлгээ, зөвлөмжийн гүйцэтгэлийг тухай бүр авч хэлэлцэн, бүхий л шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.





ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Богд банкны удирдах дээд байгууллага нь ТУЗ бөгөөд банкны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулж, ажилладаг. Удирдлагын хороо гүйцэтгэх захирлын шууд удирдлагад харьяалагддаг. Банк нь есөн газар, тэдгээрийн харьяа гучин найман алба, хэлтсээс бүрдсэн нийт хоёр зуун арван гурван ажилтантай үйл ажиллагаа эрхэлдэг.



Бид 2022 онд банкны стратегийн зорилго, зорилтуудыг хангахад хүний нөөцийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулах, банкны ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг зөв зохистой үнэлэн дүгнэх холбогдох арга хэмжээг авах замаар хөдөлмөрийн бүтээмжийг өндөр төвшинд байлгах арга зорин ажиллаа.

Нийт ажиллагсдын 50 гаруй хувь нь таваас дээш жил ажиллаж туршлага хуримтлуулсан, банкны салбарт туршлагатай ажилтнуудтай банк болсон байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ МЭНД

2022 онд нийт ажилтнуудынхаа биеийн эрүүл мэнд, дархлаажуулалтыг дэмжих зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх аян, спортын нэгдсэн өдөрлөг мөн ажилтан бүрийн ур чадвар, сургалт хөгжлийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд дотоод болон гадны мэргэшүүлэх, танин мэдүүлэх сургалт, аян, хөтөлбөрүүдийг жилийн турш тогтмол зохион байгуулж ажиллалаа.

ШАГНАЛ

Бид ажилдаа амжилт гаргаж хамт олноо манлайлан ажилласан 52 ажилтныг Төрийн дээд одон медаль, Монголбанкны шагнал, Богд банкны шилдэг ажилтнаар тус тус шагнаж, өргөмжиллөө.


ЦАЛИН, УРАМШУУЛАЛ


Богд банк нь өнгөрсөн жил ажилтнуудын цалин, хангамжийн багцыг 10-15 хувиар нэмэгдүүлж, ажиллагсдад цалингийн хөнгөлөлттэй зээлийг олгож ажилласан.

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Банк нь Компаний тухай хууль, Банкны тухай хууль, банкны хуулийн этгээдийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Монгол банкны ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох түүнд хяналт тавих журам, банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох хянах тайлагнах журам, Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг томилох чөлөөлөх журмын хүрээнд банкны үйл ажиллагааг хянах мөн Банкны дотоод Аудит нь банкны гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд ажилладаг тул өдөр тутмын үйл ажиллагааг бүрэн хянах гарч буй тушаал шийдвэрийг хянах боломжийг олгодог. Мөн түүнчлэн зохицуулах байгууллагад тухайлсан тайлан мэдээг сар бүр, улирал бүр явуулан банкны үйл ажиллагааг зохистой харьцаанд байгаа эсэх, мөн ТУЗ гишүүнээр нэмэх, чөлөөлөх тухай бүр зохицуулах байгууллага хяналт тавьж хууль журмаар хүлээсэн үүргээ зөрчсөн, зохистой харьцаа алдагдсан гэх мэт үндэслэл тогтоогдвол хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээ авах эрх Монгол банкинд хадгалагддаг.

ТООН МЭДЭЭЛЭЛ 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ БАЙДЛААР





ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны эрсдэлийн удирдлагын зорилго нь банкны бүхий л төвшинд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэл үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, эрсдэлийг хэмжих, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг оновчтой удирдах явдал юм.

Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн зүгээс үйл ажиллагааны гол чиглэлүүдийн хүрээнд баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарлалтууд болон эрсдэлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнаж ажилладаг.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Базелийн хорооноос гаргасан “Банкны зохистой засаглалын зарчимууд” болон ОУ-ын стандарт зөвлөмжүүдийг удирдлага болгон эрсдэлийн гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн засаглалыг бэхжүүлэн, эрсдэлийн удирдлагын зохистой засаглалыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Богд банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь “Хамгаалалтын гурван шугам” загварт нийцсэн байдлаар явагддаг бөгөөд хяналтын чиг үүргүүдийг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

Хамгаалалтын 1-р шугамд: Бизнес, арын албаны нэгжүүд – Эрсдэлийг хариуцах, эрсдэлийг дотоод хяналтаараа удирдах үүрэг бүхий үйл ажиллагааны нэгжүүд.

Хамгаалалтын 2-р шугамд: Бодлого, заавраар хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгжүүд – Хамгаалалтын 1-р шугамын нэгжүүдийн эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх, комплайнсын болон үйл ажиллагааны эрсдэл, чанарыг үнэлэх үүрэг бүхий хяналтын нэгжүүд.

Хамгаалалтын 3-р шугамд: Дотоод аудитын нэгж – Хамгаалалтын 1 болон 2-р шугам дахь үйл ажиллагааны нэгжүүдээс хараат бусаар баталгаажуулах үйлчилгээ үзүүлэн, үр дүнг гүйцэтгэх удирдлагад мэдээлэх болон ТУЗ-д тайлагнах үүрэг бүхий бие даасан нэгж юм.

Богд банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн стратегитай уялдсан эрсдэлийн уян хатан, оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлд гол анхаарлаа хандуулан зохицуулагч байгууллага, ТУЗ-ийн зүгээс банкны үйл ажиллагаанд тавьж буй хязгаарлалтуудыг бүрэн ханган, ажилтнуудынхаа ур чадвар, эрсдэлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, эрсдэлийн соёлыг бэхжүүлэн, эрсдэлийг үнэлэх олон улсын арга аргачлал, загварыг судлан, сайжруулж, олон улсын стандартын дагуу тооцож үнэлж ажиллалаа.



ЗЭЭЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд банкны үндсэн үйл ажиллагаа, актив, пассивын үнэ цэнэд нөлөөлөх гадаад валютын ханшийн хөдөлгөөн, хүүгийн төвшний өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг авч үзэж байна. Нөгөө талаас дотоод болон гадаадын макро эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд орж буй өөрчлөлт, банканд үзүүлэх нөлөөллийг үнэлж, эрсдэлээс сэргийлэх чиглэлд холбогдох газар нэгж, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд:

- Валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох хамгийн их алдагдлыг Базелийн хорооны зөвлөмжийн дагуух Value-at-Risk аргачлалаар тооцож, хөрөнгө зохицуулалтын газар болон гүйцэтгэх удирдлагад мэдээллийг хүргүүлж ажилласан.
- Актив, пассивын төвлөрөл, хүүний эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, гадаад валютын эрсдэл болон бусад эрсдэлүүдийн хүрээнд орчим харьцаа үзүүлэлтийг 7 хоног бүр хэмжин, тайлагнаж, холбогдох газар нэгжид мэдээллийг хүргэсэн.
- Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Банкны үйл ажиллагаанд нөлөөлөх МУ-ын макро эдийн засгийн үзүүлэлтүүд тэдгээрийн чиг хандлагын талаар судалгаа хийж, холбогдох эрсдэлийг судлан удирдлагад танилцуулж ажиллалаа.

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн эрсдэл, зээлийн багцын эрсдэл хариуцсан тусдаа хоёр нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Монголбанкны зүгээс банкуудын зээлийн эрсдэлийн чиглэлээр тавьж буй хязгаарлалтуудыг хангаж ажиллахаас гадна, ТУЗ-ийн зүгээс зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах хүрээнд зээлийн дүнгийн хязгаарлалт, зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хязгаарлалт, нэг зээлдэгч болон нийт зээлдэгчийн хязгаарлалт, бүтээгдэхүүний түвшинд тавих хязгаарлалтын харьцаа үзүүлэлтийг тус тус тогтоож, харьцаа үзүүлэлтээ тайлант хугацаанд бүрэн хангаж ажиллалаа. Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг 2025 он хүртэлх хугацаанд гаргаж зохицуулагч байгууллагын холбогдох журмын дагуу Чанаргүй активын дотоод үнэлгээг хийж ажиллалаа.

Актив ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах дотоод журам, активын үнэ цэнийн бууралт тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт СТОУС-9 -г амжилттай нэвтрүүлээ.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх чадварыг илэрхийлсэн Монголбанкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлага зэргийг авч үзэж байна. Үүнээс гадна Банкны хөрвөх чадварын эрсдэлийг мөнгөн урсгалын тайлан GAP шинжилгээ, Базелийн стандартын дагуу LCR (liquidity coverage ratio), NSFR (Net stable funding ratio) харьцаа үзүүлэлтүүдээр хэмжиж тайлагнаж байна. Эдгээр харьцаанууд нь Банкны хувьд тогтмол 100%-с дээш үзүүлэлттэй гарч байгаа нь хөрвөх чадварын эрсдэлийг зохих түвшинд байгааг илтгэж байна.

Богд банк нь тайлант хугацаанд зохицуулагч байгууллагаас тавьж буй дээрх шаардлага, харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан ба дотооддоо “Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого”-ын баримт бичгийг мөрдөж, хөрвөх чадварын эрсдэлийг эрт илрүүлэх, тэргүүлэгч индикаторуудыг тодорхойлон, хэмжиж-хянах, тухайн нөхцөл байдалд тулгуурласан оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдан ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА, КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2022 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлого, журам болон харилцагч таньж мэдэх журам болон ОХУ Украйны дайны асуудалтай холбоотойгоор болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай өөрчлөлт, хязгаарлалтуудыг авч хэрэгжүүлэн банкны нийт ажилтнуудыг энэ чиглэлийн сургалт, зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Банк үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс банкны бүх төвшинд хамгаалалтын гурван шугам загварын дагуу хяналтыг хэрэгжүүлж, давхар болон дараалсан хяналтын системийг сайжруулах, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээрх ажилтан бүрийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлд ажиллалаа.



Банк цаашид банкны нэгдсэн эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүний үр дүнд ирээдүйд учрах аюулын үр нөлөөг таньж мэдэх, оновчтой удирдах, үйл ажиллагааны аль хэсэгт илүү өндөр эрсдэл учрахыг таамаглах боломжтой болох юм.

ОХУ Украйны дайны асуудал, ОУ-ын хориг жагсаалтууд ойрхон өөрчлөгдөх болсоноос шалтгаалж гадаад гүйлгээнд харилцагчид, банкууд, тэдгээрийн удирдлага, хамаарал бүхий этгээдийг шалгах, комплайнсын эрсдэлийг бууруулах зорилгоор LexisNexis Risk management solution бүхий харилцагчийг нарийвчлан таньж мэдэх олон улсын хайлтын программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашиглаж эхэлсэн.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 ОНЫ ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



ТАЙЛАНТ ОНЫ УРАМШУУЛАЛТ АЯН

- Цагаан сарын баяртай холбогдуулан хадгаламжийн урамшуулалт аян
- Хадгаламж эзэмшигчдэд зориулсан хадгаламжийн урамшуулалт аян
- Эх үрсийн баярыг тохиолдуулан "Хүсэл түгээнэ" урамшуулалт аян
- "Яармаг" шинэ салбарын нээлттэй холбогдуулан хөнгөлөлт, урамшууллын аян
- Дугаараа дураараа сонгох үйлчилгээтэй холбоотой урамшуулалт аян
- "Драгон" шинэ салбарын нээлттэй холбоотой хөнгөлөлт, урамшууллын аян
- Дэлхийн хуримтлалын өдөр 2022 урамшуулалт аян
- Хүүхдийн хадгаламж шинээр нээлгэх болон хугацаа сунгалт хийлгэх харилцагчдадаа зориулж урт хугацааны тогтвортой харилцаа бий болгох, эх үүсвэрийн үлдэгдлийг нэмэгдүүлэх зорилгоор "Итгэл" хүүхдийн хадгаламжийн урамшуулалт аян
- "Цойлогсод Z"-д зориулсан дугаараа сонгох үйлчилгээний хөтөлбөрт аян



ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Богд банк нь иргэдийн хуримтлалыг дэмжих зорилгоор, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлөө илүү уян хатан болгох, хуримтлал бий болгох дадал зуршлыг нэмэгдүүлэх үүднээс харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлж ирсээр байгаа билээ. Бид тайлант хугацаанд хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүний хугацааг сараар сонгодог байсныг ХОНОГ-оор сонгох боломжтой болгосон. Ингэснээр харилцагч нь өөрийн хүссэн зорилгодоо нийцүүлэн хадгаламжийн хугацаагаа сонгон хуримтлалаа үүсгэх боломжтой юм.

Бид тайлант хугацаанд хадгаламж эзэмшигч харилцагчдаа урт хугацааны харилцаа холбоо бий болгох зорилгоор шинээр хадгаламж нээлгэх болон хадгаламжийн хугацаа сунгалт хийх тохиолдолд хадгаламжийн дүнгээс хамааран хугацаатай хадгаламжийн хүүн дээр нэмэлт хүүгийн урамшууллыг олгох аяныг зохион байгуулсан.

Хуримтлалыг дэмжих зорилгоор хадгаламж эзэмшигч нь өөрт цугларсан B point урамшууллын оноогоо өөрийн хадгаламжийн данс руу шилжүүлэх боломжийг нэвтрүүлсэн.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эдийн засагт оролцогчдын томоохон төлөөлөл болох бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор шинээр Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. Мөн цаг хугацаа хэмнэж, түргэн шуурхай автомашины зээл авах хүсэлтэй байгаа харилцагч нартаа зориулж Экспресс автомашины зээлийг зах зээлд нэвтрүүлж ажиллалаа.

Банк нь Ипотекийн зээл болон Урт хугацаат репо зээлийг амжилттай олгож, Монголын ипотекийн корпораци болон Үнэт цаас санхүүжилтийн корпорацид нийт 10.279 тэрбум төгрөгийн 3 багцыг амжилттай худалдсан.

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчдадаа бүх төрлийн төлбөр тооцоонд ашиглах боломжтой ₮ брэндийн төлбөрийн карт, дэлхийн аль ч улсад төлбөр тооцоогоо саадгүй гүйцэтгэх боломжтой Олон Улсын Виза болон ЮнионПэй брэндийн картуудыг санал болгож байна. Тайлант онд төлбөрийн карт 54 хувиар өсгөсөн.

ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР-2022

БОГД БАНК нь иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулагддаг “Дэлхийн хуримтлалын өдөр 2022” аянд амжилттай оролцож нийт арилжааны банкууд дундаас 2 дугаар байранд шалгарлаа. Бид уг аяны хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын 16 сургуулиудын 662 сурагчдад болон 3 асрамжийн газрын 200 хүүхэд багачуудад **“Санхүүгийн боловсрол”, “Хуримтлалын ач тус”** гэсэн сэдвийн хүрээнд сургалт, семинарыг зохион байгуулсан.
- Олон төрлийн маркетингийн арга хэрэгслийг ашиглан мэдээллийг түгээж, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулан ажилласан.
- Хүүхэд багачуудад зориулж бага наснаас нь эхлэн хуримтлал хийх дадал зуршлыг төлөвшүүлэх зорилгоор тэдний дунд гар зураг, видео бичлэгийн уралдааныг зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдэд мөнгөн дүн бүхий **хадгаламжийн дэвтэр**-ийг бэлэглэж, хуримтлалтай болох анхны алхмыг нь тавьж өгсөн.

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид байгууллагын харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн, уян хатан нөхцөлтэй харилцах болон хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Харилцагч нь хугацаатай хадгаламжаа хугацаа дуусахаас өмнө гэрээгээ цуцлахгүйгээр зарлага гаргах боломжтой SMART хугацаатай хадгаламжийг нээж өндөр хүүгийн өгөөжийг авах боломжтой юм.

CORPORATE GATEWAY ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын харилцагч нь өөрсдийн санхүүгийн программаар дамжуулан Богд банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах, төлбөр тооцоог түргэн шуурхай хийх боломжийг олгох Corporate Gateway үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Эдийн засаг, зах зээлд үзүүлж буй цар тахлын нөлөөллийг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах, эдийн засгийг сэргээх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, хамтран ажиллаж байна. Мөн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор баталгааны болон шугамын модулыг шинээр нэвтрүүлсэн. Байгууллагад зориулсан цогц бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж байна.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчийн бүх төрлийн санхүүгийн хэрэгцээг нэг цэгээс хангах зорилгоор, эрсдэлийн удирдлагын хамгийн оновчтой шийдэл болох Даатгалын зуучлалын үйлчилгээг бүх салбар нэгжээрээ дамжуулан хүргүүлж байна. Тайлант хугацаанд МИГ ДААТГАЛ ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.

Богд банк нь дараах даатгалын байгууллагуудтай хамтран ажиллаж, даатгалын зуучлалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байна.






ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Богд банк нь Байгаль орчин, нийгмийн хариуцлага, жендэрийн талаар баримтлах чиглэл, зарчим, банкны удирдлага, ажилтнууд болон харилцагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Банкнаас байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, улмаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулах, Байгаль орчин нийгэм, жендэрийн нөлөөллөөс Банкны үйл ажиллагаа болон Богд банкны харилцагчдад үүсэх эрсдэлийг бууруулах, хянах, удирдах үйл ажиллагааг зохицуулах үүднээс 2022 онд “Богд банкны байгаль, орчин, нийгмийн хариуцлага, жендэрийн эрх тэгш байдлын бодлого” гэсэн баримт бичгийг батлуулж, улмаар үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна. Банк нь анх 2015 онд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг батлуулж байсан бөгөөд, жил бүр тухай бодлого баримт бичгээ шинэчлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирсээр байна.

Бид байгаль орчны бодлогын хүрээнд хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийг бууруулж ажиллахыг зарчим болгож ажиллаж байна.



Бид ТоС-ын хэрэгжилтийн ил тод байдлыг сайжруулах үүднээс 2022 оноос эхлэн улирал бүр Богд банкны ТоС-ын ажлын хэсгийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан улирлын тайланг өөрсдийн вэбсайтад оруулж ил тод болсон билээ. Мөн бид Хувьцаат компани болсонтой холбогдуулан, хагас жилийн тайлангаа олон нийтэд хүргэсэн ба тус тайланд ТоС-ын хэрэгжилттэй холбоотой тусгайлан хэсгийг танилцуулсан. Бид цаашид ТоС-ын ерөнхий ойлголт ба олон нийтийг мэдээллээр хангах ажлыг идэвхтэй хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ТОС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ.

БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХ

2022 оны эх үрсийн баяртай холбогдуулан зохион байгуулсан “Хүсэл түгээнэ” урамшуулалт аяны хүрээнд хүүхдүүдэд бэлэглэсэн бэлэгний торыг ЭКО тороор бэлтгэн бэлэглэсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2021 оны намар Сонгино хайрхан дүүргийн 24 дүгээр хороонд байршилтай Бумбатын булаг нэртэй газарт Монголын Банкны холбооны дэргэдэх бусад арилжааны банкнуудтай хамтран 2000 мод тарьсан билээ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд бид 2022 оны 5 сарын 19-ний өдөр өнгөрсөн онд тарьсан модоо эргэн очиж, усалж, арчилгаа хийж нөхөн сэргээлээ.

Мөн 2022 оны 5 сарын 27-ны өдөр Монголын банкны холбоо болон гишүүн арилжааны банкууд нь “Төгс хандлагаа өөрчилье” ТББ-тай хамтран Богдхан ууланд 700 ширхэг шинэс модны суулгац тарьсан.

Бодь даатгал ХК болон Бодь цамхаг ХХК нь хамтран 2022 оны 10 сарын 19-ний өдөр Гачууртын Их Дэндий аманд 140 улиас, 40 нарс, 1 гацуур болон 1 шинэс модны суулгац тарьж өөрсдийн төглийг байгуулсан.

Бид өдөр тутмын үйл ажиллагаандаа нөөцийн хэмнэлтийг идэвхтэй хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд цаасны хэрэглээг бууруулах үүднээс бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, брошурыг цахим хэлбэрээр бэлтгэн арга хэмжээнд оролцож байна. Монголбанк, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпорац, ХБНГУ-ын “Шпаркассэ” банкны Монгол дахь сангаас жил бүр зохион байгуулдаг “Дэлхийн хуримтлалын өдөр 2022” оны арга хэмжээнд амжилттай оролцсон бөгөөд тус арга хэмжээгээр дамжуулан Богд банкны цоо шинэ цахим салбар болох Meta Bank (анхны цахим салбар буюу нөөцийн хэмнэлтийн хэрэгжүүлсэн)-аа танилцуулж, бүтээгдэхүүн үйлчилгээний брошурыг QR хэлбэрээр олон нийтэд хүргэсэн. Банк нь цаашид ч мөн олон нийтийн арга хэмжээ болон өдөр тутмын үйл ажиллагаандаа нөөцийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Бид Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, Үндэсний дата төв, УБЕГ, Монгол банк, E-Mongolia академитай хамтран лавлагааны дундын систем /Lavlagaan.emongolia.mn/ хөгжүүлж, нийт 69 төрлийн лавлагааг цахим хэлбэрээр хялбар шуурхай үзүүлэх ажлыг банкны салбар үйлчилгээнд нэвтрүүлэх санааг бичигт гарын үсэг зурж, нийт салбаруудаараа үйл ажиллагааг нэвтрүүлсэн бөгөөд лавлагааг цахим хэлбэрт шилжүүлэх нь цаасны хэмнэлтэд томоохон нөлөө үзүүлж байгаа юм.

ХҮНИЙ ЭРХ, НИЙГМИЙГ ХАМГААЛАХ

Нийгмийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд “Залилан гэмт хэргээс сэргийлэх сургалт”-д Банкны нийт ажиллагсдаа хамруулсан.

Бид Жендэрийн эрх тэгш байдлын асуудал нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал бус бөгөөд энэ нь Банкны болоод нийт улс орны эдийн засагтай шууд хамааралтай гэж үздэг бөгөөд тайлант хугацаанд Банк нь хүний нөөцийн бодлого болон өдөр тутмын үйл ажиллагаандаа жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллахыг эрмэлзэн ажиллагсдаа зориулж “Ажлын байран дахь жендэрийн ойлголт”-ын тухай мэдээллийг бэлтгэн тогтмол хүргэн ажиллаж байна.

НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

Банк нь ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс Эко автомашины зээл, Ногоон хэрэглээний зээл болон Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг тус тус нэвтрүүлэн харилцагчдадаа санал болгож байна.

Бид ногоон зээлийг санхүүжүүлэх болон жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор гадаадын Enabling Capital хөрөнгө оруулалтын сангаас 2 удаа, АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацаас (DFC) санхүүжилт тус тус амжилттай татсан.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ

Бид иргэдийн ТоС-ын ерөнхий ойлголтын тухай мэдлэгийг дээшлүүлэх дээр ач холбогдол өгч, Байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагын тухай мэдээллийг тогтмол маркетингийн сувгаар дамжуулан хүргэж байна.

ЁС ЗҮЙТЭЙ САНХҮҮЖИЛТ, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

Компанийн засаглалыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд ТУЗ-ийн бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлж 7 гишүүн байсныг 9 болгон өөрчлөлт оруулсан.

Мөн 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 22/63 тоот ТУЗ-ийн тогтоолоор 2022 оны 2 дугаар улирлын татварын дараах цэвэр ашгаас ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа 62,50,000.00 ширхэг хувьцаанд ноогдуулан тараахаар шийдвэрлэсэн.

Бид тайлант хугацаанд Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн "Богд банкны Байгаль орчин, нийгмийн хариуцлага, жендерийн эрх тэгш байдлын бодлого"-г шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Богд банк нь жижиг, дунд үйлдвэрлэл, тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, санхүүжилтээ нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ажиллаж байгаа билээ. Банк нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд 1 жил болж байгаа бөгөөд тайлант хугацаанд энэхүү зээлийн санхүүжилтээр маш амжилттай үйл ажиллагаагаа явуулж буй "Express Laundry-Өөртөө үйлчлэх авто угаалгын төв"-ийг олон нийтэд ил тод мэдээллийг хүргэн ажиллалаа.

ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫГ ДЭМЖИХ

Бид ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТоС-ын ажлын хэсгийн хэрэгжүүлсэн ажлуудыг улирлын тайлан хэлбэрээр олон нийтэд түгээдэг болсон. Мөн жил бүр банкны жилийн тайлан болон хагас жилийн гүйцэтгэлийн тайланд тус тус ТоС-ын үйл ажиллагааг танилцуулж ил тод байдлын хариуцлагыг дэмжин ажиллаж байна.

МАНЛАЙЛАН ҮЛГЭРЛЭХ

Банк нь дотоод үйл ажиллагаандаа нөөцийн хэмнэлт буюу цаасны хэрэглээг бууруулах үүднээс цаасны хэрэглээг хамгийн ихээр ашигладаг баримт бичгийн төслийг системээр дамжуулан боловсруулж, баталгаажуулах ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Мөн бид дотоод үйл ажиллагаандаа дахин боловсруулсан цаасаар үйлдвэрлэсэн тэмдэглэлтэй бичиг хэргийн зүйлсийг ашиглах болон дахин цэнэглэсэн принтерийн хорыг ашиглах дээр ач холбогдол өгч, хэрэгжүүлж байна.



САЛБАРЫН УДИРДЛАГА

Бид 2022 онд үйл ажиллагаагаа тэлж, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Хан-Уул дүүрэг буюу Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүсэд Яармаг салбар, Сонгинохайрхан дүүрэгт Драгон салбараа тус тус шинээр нээж, харилцагчдадаа улам ойртлоо.

Ингэснээр, Богд банкны харилцагчид Улаанбаатар хотын бүх дүүрэгт орших салбар нэгжээр дамжуулан банкны бүхий л үйлчилгээг найдвартай, түргэн шуурхай авах боломжтой болов.

САЛБАРЫН ТОО:



ШИНЭЭР НЭЭГДСЭН САЛБАРУУД:



Хаяг: Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Наадамчдын гудамж, Фүүд сити худалдааны төвийн 4 давхарт

Цагийн хуваарь:

Даваа-Баасан 10:00 – 19:00
Бямба, Ням: Амарна



Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москвагийн гудамж, Драгон төвийн 2 давхарт

Цагийн хуваарь:

Даваа-Баасан 09:00 – 18:00
Бямба, Ням: Амарна

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Богд банк харилцагчийн үйлчилгээгээ улам сайжруулж, харилцагч төвтэй банк болох зорилгоор жил бүр харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг хийж гүйцэтгэдэг бөгөөд энэ жилийн судалгааны үр дүнд харилцагчдад хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар болон хүртээмж, үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн болон харилцааны ур чадварын түвшнийг тодорхойлсон ба тэдгээр үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах бодлогыг үйл ажиллагааны төлөвлөгөө болон урт хугацааны стратегид тусган, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Банкны харилцагчийн үйлчилгээг өнгөрсөн онд цогцоор сайжруулж, бүтээгдэхүүний идэвхжүүлэлт урамшууллыг зарлаж ажилласан бөгөөд үр дүнд нь:

1. Богд банкны нийт харилцагчдын тоог өмнөх оноос 63 хувиар өсөв.
2. Картын борлуулалтыг идэвхжүүлж, карт эзэмшигчдийн тоог 2 дахин өсгөв.
3. Картаар үйлчлэгч байгууллага буюу ПОС эзэмшигчдийн тоог 105 хувиар өсгөв.

Банкны харилцагчдадаа үнэн зөв мэдээллийг бүхий л цаг үед өгч ажиллах хүрээнд Харилцагчийн мэдээллийг төвийн программын шинэчлэл хийж, орон тоог нэмэгдүүлсэн бөгөөд өнгөрөгч онд нийт 30 мянга гаруй дуудлагад хариулж, давхардсан тоогоор 50,000 орчим харилцагчдад олон нийтийн сүлжээгээр дамжуулан хэрэгцээт мэдээ мэдээллийг өгч ажиллаа. Түүнчлэн, харилцагчийн мэдээллийг төвд ирсэн нийт гомдлын 90 орчим хувийг 24 цагийн дотор шийдвэрлэж, харилцагчийн сэтгэл ханамжийг өсгөхөд анхаарч ажиллав.





МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

2022 онд Мэдээллийн технологийн газраас Мобайл банк Интернэт банкныхаа ашиглалтыг дэмжих, илүү хэрэгцээт болон хөгжүүлэхээр зорьж ажилласан.




POS

ПОС машинаасаа И-Баримт олгох боломж бүхий систем нэвтрүүлсэн.

BOGD MOBILE

- Дансны дугаараа харилцагч өөрөө сонгох бүхий боломж
- Favorite / Recent гүйлгээ
- Данс болон картын гүйлгээний лимит
- Картын тохиргоо хаах / нээх
- Карт захиалгын явц
- Шуурхай гүйлгээ
- БОГД булан
- World Cup - Тааварт тоглоом




CORPORATE GATEWAY

Excel болон Corporate Gateway ашиглан зээл олголт, эргэн төлөлт, төлбөрийн график, тусгай дансны дүрэм үүсгэн Ebogdbank.com ашиглан өдөр тутмын үлдэгдэлээ хянах боломж бүхий Багцын зээл худалдан авах авто шийдэл нь өндөр үр өгөөжтэй байна.

- Мэдээллийн сангийг датагуардтай холбож, сүүлийн үеийн хүчин чадалтай сервер лүү шилжүүлэн өгөгдлийн сангийн сайжруулалтын тохиргоог хийснээр онцгой байдлын үед нөөц төв рүү шилжих хугацааг 5мин дотор гүйцэтгэх боломжтой болгосон. Мөн баазын ачааллыг 200%иар бууруулав.
- Үндсэн систем NES-ийн НӨАТ болон Баталгааны модул шинээр нэвтрүүлсэн
- Зээл худалдан авах үйлчилгээ нэвтрүүлсэн
- Цаг бүртгэлийн системийг карт уншуулах аргаар шийдвэрлэсэн





ЗЭЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

- 2022 онд банкны хэмжээнд нийт 17,131 харилцагчид 306 тэрбум төгрөгийн зээл олгосноос 40%-д нь зээлийн эрсдэлийн дүгнэлт гаргаж нэгж зээлийн эрсдэлийг бууруулах, хамгийн бага түвшинд байлгах чиглэлээр тасралтгүй ажиллаж байна.
- Банкны хэмжээнд зээлтэй холбоотой тайлан мэдээг гаргаж холбогдох газар хэлтэс, гадны байгууллагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангасаар ирсэн.
- Зээлийн тайлантай холбоотой автоматжуулалтыг холбогдох газар хэлтэстэй хамтран сайжруулсан.
- Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу зээлийн гэрээ, барьцаа хөрөнгийн бичиг баримтын хадгалалтыг төвлөрүүлэх, бүртгэлийг сайжруулах ажлыг хийж дуусгалаа
- Харилцааны менежерүүдийг судалгаа, хяналт хийх чиглэлээр сурган дадлагажуулсан.
- Зээлийн чиглэлээр газар дээрх хяналт хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авсан.
- Богд банк нь банкны системд чанаргүй зээлийн үзүүлэлтээр хамгийн бага байгаа нь бидний авч хэрэгжүүлсэн нэгжийн зээл шийдвэрлэх эрхийг зохистой тогтоох, зээлийн дансыг нээхээс өмнө авто шалгахад шийдэл олох, зээлийн өргөдлийн мэдээллийг бүртгэх, харилцааны менежерүүдэд сургалт орох, газар дээрх хяналтыг эхлүүлэх гэх мэт арга хэмжээний үр дүн гэж харж байна.

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ГАЗАР

ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

Богд банк нь зохицуулагч байгууллагуудаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг банкны Актив, пассивийн удирдлагын бодлогын дагуу тогтмол давуулан биелүүлж төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 39.4%, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 36.75%-тай хангаж ажиллаа. Үүний үр дүнд 2022 оны хагас жил болон жилийн эцсийн цэвэр ашигаас нийт 1568 хөрөнгө оруулагчиддаа 2 удаа ногдол ашиг тараалаа.

Монголбанк болон засгийн газраас ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй Урт Хугацаат Репо санхүүжилтын зээлийн хөтөлбөрт Богд банк идэвхитэй оролцож Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгож, цар тахлын үед нийт эдийн засгийн өсөлтөө дэмжих үйлсэд хувь нэмрээ оруулж ажиллалаа.

ВАЛЮТ АРИЛЖАА

Богд банк нь дотоодын валют арилжааны зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж цахим банк болон салбар, тооцооны төвүүдээр дамжуулан харилцагчдын валют арилжааны эрэлт, нийлүүлэлтийг 8 төрлийн валютаар хурдан шуурхай, уян хатан нөхцөлөөр гүйцэтгэж ажиллалаа. 2022 онд “Ковид-19” цар тахлын хорио цээр багасаж Монгол улсын гадаад худалдааны эргэлт ихэссэнээр харилцагчдын валютын эрэлт огцом өссөн бөгөөд тус хугацаанд банкны нийт валют арилжааны эргэлт өмнөх оны мөн үеэс 23 дахин өссөн байна. Мөн харилцагчдынхаа валютын эрэлт, нийлүүлэлтийг ханган ажиллах, импорт, экспортын бизнес эрхэлдэг дотоодын томоохон харилцагч байгууллагуудаа ханшийн эрсдлээс хамгаалах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болох своп, форвард арилжааны хэлцэл санал болгон хэрэгжүүлж ажиллалаа.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Богд банк нь 2022 онд олон улсын хамтын ажиллагаагаа улам тэлэн хэрэглэгчиддээ шаардлагатай санхүүжилтээр хангах үүднээс нийт 19 сая ам.долларын эх үүсвэрийг татсан байгаа билээ.

Эдгээрээс 4 сая ам.долларыг Линхештейны Enabling Capital зөвлөх байгууллагатай EMF Microfinance Fund-тай 7 сарын 7 болон 10 сарын 26-нд нийт 2 удаа гэрээ амжилттайгаар байгуулан дунд хугааны санхүүжилтийг татсан байна. Уг санхүүжилт нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчидэд чиглэсэн ба ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн хөгжлийг дэмжих, харилцагчдын эрэлт хэрэгцээг ухаалгаар шийдвэрлэх тал дээр илүү анхааран ажиллах боломж өгч буй зэрэг олон ач холбогдолтой.

Мөн манай банк нь DFC буюу АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацитай 2022 оны 12 сарын 21-нд амжилттайгаар 15 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг байгуулсан байна. Энэхүү санхүүжилтийн хувьд мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд чиглэсэн боловч жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид дундаа эмэгтэй бизнес эрхлэгч болон ногоон зээл рүү төвлөрснөөр онцлог юм. АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацын энэхүү санхүүжилтээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, улмаар НҮБ-аас тунхагласан Тогтвортой хөгжлийн зорилтууд, тодруулбал, жендэрийн эрх тэгш байдлыг хангах (5), эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (8), тэгш бус байдлыг бууруулах (10), уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (13) зэрэг зорилтыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх юм.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД








Богд банкны нийт хөрөнгө 2022 оны эцсийн байдлаар 476.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 46%-аар өссөн. 2014 онд байгуулагдсан цагаасаа хойш нийт хөрөнгө 28.6 дахин өссөн бөгөөд жил бүр дунджаар 51 хувийн өсөлт үзүүлсэн байна.

Өөрийн хөрөнгө 116.62 тэрбум төгрөгт хүрснээр өнгөрсөн 8 жилийн хугацаанд өөрийн хөрөнгөө 700 хувиар өсгөж, жилд дунджаар 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 онд нийт 19.05 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2021 оны 10.78 тэрбум төгрөгийн ашгийн үзүүлэлттэй харьцуулахад 77%-иар өссөн байна.

2022 оны 12-р сарын 31-ий байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/16.4%-тай, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 39.4%-тай байна.

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД





БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ



Богд цамхаг - 4-н давхар, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com